

НИЙГМИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛД УЛС ТӨРИЙН ХҮЧИН ЗҮЙЛИЙН НӨЛӨӨЛӨЛ

Д.БОЛД-ЭРДЭНЭ

Доктор, ФСЭХ-ийн Улс төр судлалын салбарын
эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан

Abstract: Political factor has a crucial role in social and economic development. Fundamental research of political factor impact is essential in order to get a correct vision of trends in political and economic development. Thus, some important issues related to political and socioeconomic development will be discussed in the article.

Нийгмийн эдийн засгийн хөгжилд улс төрийн хүчин зүйлийн нөлөөллийн тухай асуудал нь онолын хувьд ч, практикийн хувьд ч нэн сонирхолтой. Энэ нь шууд агуулгаараа нийгмийн эдийн засаг, улс төрийн харилцан хамаарал, нөлөөллийн тухай асуудал юм. Өнөө үед энэ нь улс төр шинжээчдийн онолын өргөн маргаан мэтгэлцээний гол сэдэв болоод зогсохгүй нийгмийн ардчилсан өөрчлөлтийн загварын түвшинд яригдах практик учир зүйн том асуудал болж буй юм.

Нийгэм нь хоорондоо харилцан хамааралтай олон талт салбар, хүрээ бүхий бүхэл амьд тогтолцоог бүрдүүлдэг. Нийгмийн энэхүү тогтолцоот бүрдэл нь эргээд тогтолцоот хөгжлийг нөхцөлдүүлдэг. Үүнээс үүдэн нийгмийн эдийн засаг, улс төр, оюун санааны хүрээний хөгжлийн тусгай тодорхой салбар чиглэлүүд гарч ирдэг. Гэвч тэдгээр нь бие биенийхээ харилцан нөлөө, дэмжлэггүйгээр оршин үйлчилж, үр өгөөжөө өгөх боломжгүй. Чухам эндээс л нийгмийн амьдралын эдийн засаг, улс төрийн талын харилцан хамаарал, түүнээс үүдсэн нөлөөлөл, тэдгээрийн цогц хөгжлийн тухай асуудал гарч ирдэг.

Ойлголт, баримтлалын товч тойм

Эхний удаад “хөгжил” хэмээх ойлголтын тухайд товч авч үзье. Манай ахмад философич Б.Даш-Ёндон “Монголын хөгжлийн философи: асуудал, аргачлал, ашиг тус” хэмээх бэсрэгхэн бүтээлдээ “хөгжил” хэмээх ойлголт нь үгийн гарал зүйн хувьд Грекийн “аналитиксис”¹ дэлгэрэх, задрах, дэвжих\үгнээс гаралтай болохыг тэмдэглээд түүнийг Аристотель юмсын мөн чанартай* холбон авч үзэх явцдаа алив өөрчлөлт нь юмсын мөн чанарт л байдаг төгс шинж болохыг онцолсон тухай дурьдсан байдаг.² Харин “Аристотелийн аналитиксис гэдэг энэ ...үгийн агуулгад “рост”\өсөлт\ гэсэн санаа ч цээшдээ орох болсон байна. Ингэсээр яваад эцэстээ 1750-иад оны дунд үе гэхэд Германы их философич К.Ф. Вольф энэ үгийг шинээр бүрэлдэх үйл явцыг, хуучин нь ямар нэгэн шинэ зүйл болж өөрчлөгдөх үйл явцыг тэмдэглэх философийн нэр томъёо болгон хэрэглэжээ.”³ Энэ үеэс “хөгжил” гэсэн нэр томъёо философи, улс төр, эдийн засгийн мэдлэгийн салбарт гүнзгий нэвтрэх болсон байна. “Хөгжил” хэмээхийг одоо өсөлт, ахиц дэвшил, хүсүүштэй давуу тал, шинэлэг өөрчлөлт гэх зэрэг янз бүрийн агуулгаар мэдлэгийн олон салбарт өргөн хэрэглэж байна.

Орчин үед нийгмийн хөгжил, ардчилалын үйл явцыг нэгэн бүхэл цул агуулгаар харилцан хамааралтай авч үзэх болжээ. Тиймээс ч өнөө үед “хөгжил”, “нийгмийн хөгжил”, “ардчилсан өөрчлөлт” хэмээх нэр томъёог хооронд нь нягт холбоотой ойлгон авч үзэх болсон. Үүнтэй холбогдон “хөгжил” гэсэн ойлголтыг ардчиллын ахиц дэвшил, чанарын өөрчлөлт гэсэн агуулгаар түлхүү хэрэглэх болсон нь санамсаргүй хэрэг биш юм. Ингэхлээр нийгмийн хөгжлийн аль нэг асуудлыг ардчиллын бэхжилтийн тодорхой асуудалтай холбон үзэх болсон нь бараг жам ёсны зүйл болжээ. Энэ баримт нь шууд агуулгаараа хөгжил дэх улс төрийн хүчин зүйлийн нөлөө, үүргийг түлхүү онцолсоны илрэл ч гэж хэлж болохоор байдаг.

Орчин үед нийгмийн хөгжил, ардчилсан өөрчлөлтийн тодорхой угтвар нөхцөл гэдэгт шинжээчид байгаль, цаг уур, газар зүйн хүчин зүйлийн зэрэгцээ улс төрийн түүхэн уламжлал, бодит улс төрийн тухайн тодорхой нөхцөл байдал, нийгэм-эдийн засгийн хөгжлийн түвшин, дундаж болон чинээлэг давхаргын нийт хүн амын дунд эзлэх хувийн жин, хүн ардын ухамсар, оюун санааны хөгжил, төлөвшлийн хэр хэмжээ зэргийг багтаан үзэх болсон. Ингэхдээ тэд нийгмийн эдийн засаг, улс төрийн

* Аристотель байж байгаа юм байгаагаараа байхыг “мөн чанар” хэмээдэг байжээ.

¹ Б.Даш-Ёндон. “Монголын хөгжлийн философи: асуудал, аргачлал, ашиг тус” УБ.,2013, 12-14 дахь талыг үзнэ үү

² Мөн тэнд. УБ.,2013, 14 дахь тал

талын харилцан хамаарал, тэдгээрийн бие биенээ дэмжин тэтгэсэн харилцаа хөгжлийн том хүчин зүйл болдогийг ч зүй ёсоор онцолж байна.

Орчин үед эдийн засаг бие даан оршин тогтнох бололцоотой юу?, эдийн засаг, улс төрийн өөрчлөлтийн алийг нь эн тэргүүнд хэрэгжүүлэх вэ? эсвэл тэдгээрийг цаг хугацаа, орон зайн хувьд хамтад нь хэрэгжүүлэх нь зохистой юу? гэх зэрэг асуудал судлаач, шинжээчдийн анхаарлыг ихээхэн татах болсон. Тэгэхдээ энэхүү асуудлууд нь эцсийн дүндээ эдийн засаг, улс төрийн харилцан хамаарал, нөлөөллийн асуудал болох нь ойлгогддог. Өнөө үед эдийн засгийн хөгжилд үзүүлэх нөлөө, хүчин зүйлийн асуудал онцгой анхаарагдах болсон. Америкийн судлаач Карл Полани "эдийн засгийн онолд эдийн засаг нь бие даасан, хараат бус байна гэдэг боловч үнэндээ энэ нь ташаа зүйл бөгөөд эдийн засаг нь улс төр, шашин шүтлэг, нийгмийн харилцаанаас хамааралтай оршдог" хэмээн үзэхийн сацуу "эдийн засгийн тогтолцоог зах зээлээр хянах нь нийгмийн бүхий л байгууллагуудад маш хүчтэй үр дагавар авчирна. Энэ нь нийгмийг зах зээлээс хамааралтайгаар удирдан зохицуулана гэсэн үг юм"³ гэдгийг онцлоод цааш нь "бүхэлдээ өөрөө өөрийгөө зохицуулах зах зээлийн эдийн засаг гэдэг бол байж болошгүй үл гүйцэлдэх зүйл"⁴ гэсэн байр суурийг хатуу илэрхийлсэн байдаг. Энэ нь шууд агуулгаараа эдийн засгийн салбар болон түүний хөгжил нь бие дааж бус, харин амьдралын бусад хүрээ салбартайгаа нягт уялдаатай байж, тэдгээрийн дэмжлэг, нөлөөллөөс хамааралтай байдаг гэсэн санааг илэрхийлж буй хэрэг. Эндээс эдийн засгийн хөгжил ба улс төрийн харилцааны асуудал гарч ирдэг.

Өнөө үед эдийн засгаас улс төрд; улс төрөөс эдийн засагт үзүүлэх нөлөө, үүргийн асуудлыг судлаачид ихээхэн сонирхох болжээ. Энэ хүрээнд хөгжил ба улс төр, улс төр ба хөгжлийн харилцан хамаарлын асуудлыг тойрсон улс төр шинжээчдийн өргөн маргаан хүчтэй өрнөх болсон. Энэ маргааны явцад С.Липсет, Р.Барго, А.Прзевски, М.Халперин, Ж.Сийгл, М.Уайнштэйн нарын судалгаа анхаарал татдаг. Тэр дундаа С.Липсетийн эдийн засаг-нийгмийн хүчин зүйлийг улс төрийн хөгжилтэй холбон тайлбарласан судалгаа гойд сонирхолтой юм. С.Липсет нь ардчилал ба хөгжлийн харилцан хамаарлын хүрээнд хөгжлийн хүчин зүйлийг онцлон үзсэн судлаач. Тэрээр нийгмийн модернизацийн ерөнхий үйл явц ардчилал тогтох нөхцлийг бүрдүүлсэн гэж үзээд аж үйлдвэржилт, хотжитын үйл явцыг дагалдан боловсрол бүхий дунд анги бий болсон; эдүгээчлийн үйл явцын үр дүнд иргэний нийгэм хөгжсөн; нийгэм улам бүр нарийн төвөгтэй болсоноор авторитар удирдлага бүтэлгүйтсэн; хөгжил өөрөө дарангуйлагч дэглэм унахад хүргэсэн гэж нотлоод үүний жишээ болгож Испани, Португал, Грек, Өмнөд Солонгос, Тайван зэрэг орныг онцолсон байдаг.⁵ Харин Р.Барго эдийн засгийн хөгжил, түүний дотор нийт хүн амд дундаж давхаргынхны эзлэх хувь хэмжээ нэмэгдсэн болон нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүн, анхан шатны сургуульд хамрагдах байдал зэргээр илүү орнуудад ардчилал тогтвортой байгаа нь С.Липсетийн таамаглалыг батлаж байна хэмээсэн байдаг.⁶ Тэгвэл А.Прзевски улс орон эдийн засгийн хувьд хөгжихийн хэрээр ардчилал, хөгжлийн бэхжилт илүү байдаг гэсэн байна.

Харин ардчилсан улс төрийн орчин, дэглэм эдийн засаг нийгмийн хөгжилд илүү таатай нөхцөл, боломжийг бүрдүүлдэг гэсэн үзэл баримтлалыг М.Халперин, Ж.Сийгл, М.Уайнштэйн нар тууштай илэрхийлсэн байдаг. Тэд улс төр, эрх зүйн орчны боловсронгуй байдал нь нийгмийн хөгжил, ардчилал ялж бэхжихэд чухал үүрэгтэй гэж үзсэн байдаг. Үүнээс гадна хөгжилд авторитар дэглэм давуу нөлөөтэй гэсэн байр суурь ч тааралддаг. Эндээс үзвэл эдийн засгийн хөгжил, ардчилал, улс төрийн харилцан хамаарлын асуудлаар судлаачид нэг мөр үзэл, байр суурьтай болж хараахан чадаагүй нь харагдаж байна.

Өнөө үед нийгмийн хөгжилд үзүүлж буй эдийн засаг, улс төрийн хүчин зүйлийн нөлөө үүргийн тухайд улс төр шинжээчид үзэл, байр суурийн янз бүрийн талаас хандах болжээ. Тухайлбал тэд "хөгжлийн шалтгаан", "хөгжлийн нөхцөл" гэсэн хоёр ойлголтыг зааг ялгаатай авч үзэх нь зүйтэй гэсэн санааг гаргаж ирж байна. Энэ хүрээнд зарим судлаачид эдийн засгийн хөгжил нь ардчилал ялж тогтох зайлшгүй шалтгаан бус, харин оршин тогтнож бэхжихэд зайлшгүй шаардагдах нөхцөл гэсэн дүгнэлт хийх болсон нь Монголчууд бидний хувьд нэн хамааралтай, сонирхолтой асуудал болж байгаа юм.⁷

³ Polanyi, K. 2001. The Great Transformation: The Political and Economic Origins of Our Time. Boston: Beacon Press.

⁴ Block, P. 2001. "Introduction" in Polanyi, K. The Great Transformation: The Political and Economic Origins of Our Time. Boston: Beacon Press. pp. 15

⁵ Lipset, Seymour. Some social requisites of democracy: Economic development and Political legitimacy. American political science review. 1959, A comparative analysis of the social requisites. 1993.

⁶ Determinants of Economic Growth. 1997, Determinants of democracy. 1999

⁷ М.Батчимэг: Эдийн засгийн өрнөл ба улс төрийн замнал. "Социализмын дараах Монголчууд: улс төр, эдийн засаг, шашин" УБ, 2012, 69 дахь тал

Эндээс үзвэл бидний ойлгож байгаагаар нийгэм, ардчиллын хөгжил өөрчлөлтөнд нөлөө үзүүлж буй үндсэн нөхцөл гэдэгт түүнд нөлөөлж буй эдийн засаг, нийгэм, улс төр, оюун санааны хүчин зүйлийн тус тусын онцлог үйлчлэлийг ойлгож болохоор байдаг бол харин хөгжлийн үндсэн шалтгаан гэдэгт тэдгээрийн нийлж нэгдсэн цогц нөлөөллийн үйлчлэл, үр дүнг ойлгож болох юм. Тэгэхлээр нийгмийн хөгжилд үзүүлж буй эдийн засаг, улс төр болон бусад талын хүчин зүйлийн нөлөөллийг үндсэнд нь нийгмийн хөгжлийн үндсэн нөхцөл гэдэг агуулгаар ойлгон баримжаалж болохоор байна.

Нийгмийн хөгжилд нөлөөлж буй эдийн засаг, улс төрийн харилцан хамаарлын асуудлын хүрээнд дараах хэдэн гол зангилаа асуудлыг анхааралдаа авах нь зүйтэй байх. Үүнд: нэгд эдийн засгаас улс төрд эсвэл улс төрөөс эдийн засагт нөлөөлөх нөлөөлөл; хоёрт тэдгээр хүчин зүйлийн харилцан нөлөөллийн арга механизм; гуравт нөлөөллийн үр дүн, үр дагаварын асуудал эдгээр болно. Гэвч энэ бүхэн нийлээд цогц том өргөн агуулгатай байх тул нэг удаагийн өгүүллийн хүрээнд бүгдийг нь багтаан авч үзэх боломж хомс байна. Иймд энэ удаад дээр онцолсон зөвхөн эхний асуудлын хүрээнд тэгэхдээ улс төрөөс эдийн засагт үзүүлэх нөлөө, үүрэгтэй холбогдох зарим асуудлыг нэн ерөнхий байдлаар товч тоймлон үзэх болно.

Улс төрөөс эдийн засагт үзүүлэх нөлөөллийн тухай

Монголын ардчиллын шалтгаан, нөхцөлийг судалсан өрнөдийн зарим улс төр шинжээчид Монголыг ардчилал оршин тогтноход хамгийн магадлал багатай газар^{*} гэж оношлон бичсэн нь тааралддаг. Гэвч энэ дүгнэлт нь Монгол дахь ардчилсан шилжилтийн эхэн үеийн нөхцөл байдалтай илүү тохирох юм шиг санагддаг. Учир нь Монгол улс газар зүйн хувьд Өрнө, Дорнын ардчилсан орнуудаас тусгаарлагдмал, урьд өмнө ардчилсан нийгэм байгуулж байсан түүхэн уламжлал, туршлага гэхээр зүйл байхгүй, дөнгөж ардчилалд хөл тавьж байсан он жилүүдэд ажилгүйдэл, ядуурал газар авч, нийгмийн эдийн засгийн нөхцөл байдал социализмын дампуурлын дараах шокноос гараагүй, хүн ардын нийгэм-сэтгэл зүй, улс төрийн ухамсар тогтворгүй байсан зэрэг хүчин зүйлийг тооцож үзвэл дээрх судлаачдын дүгнэлттэй санал нийлж болохоор байдаг. Гэвч ардчилсан үнэт зүйлсийг туйлын зорилгоо "идеал" болгож, түүнийг ам хэлээр бус, харин бодит ажил хэрэг, хамтын хүч чармайлтаар цогцлоож чадвал байгаль, газар зүйн болон бусад талын таагүй нөхцөл, хүчин зүйл, саад бэрхшээлээс заавал ч үгүй хамааралтай байх албагүй гэдэг нь нэн тодорхой зүйл билээ. Тэгэхдээ л дээрх судлаачдын хийсэн санаа дүгнэлтийг цаг ямагт анхааран харгалзахад илүүдэх зүйлгүй юм. Харин энэ тохиолдолд Монголын ардчиллыг бэхжүүлж, түүнийг чанарын шинэ шатанд гаргах чиглэлд илүү их зүйл хийх нь чухал байгааг тэмдэглэе.

Улс төрөөс эдийн засагт тэр дундаа түүний хөгжилд үзүүлэх нөлөөллийн асуудал нь агуулга, хамрах хүрээний хувьд нэн өргөн багтаамжтай. Нарийвчлан үзвэл энд улс төрийн бүхий л тал, хүрээ салбар, хүчин зүйлийн асуудалтай холбогдох туйлын цогц олон асуудлыг хөндөх хэрэгтэй болно. Харин энд дурьдан буй асуудалтай холбогдох зарим цөөн зүйлийг товчхон хөндөхийг оролдох юм.

Улс төрийн амьдралын хүрээ нь нийгмийн бусад хүрээ, салбартай харьцуулахад онцлог. Энэ нь амьдралын бусад салбарыг удирдан чиглүүлдэг, зохицуулдаг, дагаж мөрдөх журам, хэм хэмжээг нь тогтоож өгдөг түүний үндсэн чиг үүрэгтэй нь холбоотой. Чухамдаа улс төрийн энэ бүх чиг үүрэг нь эдийн засгийн хөгжилд үзүүлэх түүний нөлөө, оролцоог нөхцөлдүүлдэг. Энэхүү нөлөөлөлтэй холбогдуулан энэ удаад нийгмийн эдийн засгийн хөгжилд үзүүлэх *улс төрийн цогц оновчтой бодлого, баримтлал; эрх зүйн орчны үр ашигтай нөлөөлөл; улс төрийн тогтвортой байдал; хяналт-хариуцлагын механизмын нөлөөллийн тухай асуудлыг* тоймлон авч үзэх болно.

Нийгмийн хөгжлийн цогц оновчтой бодлого ба нөлөөлөл. Хөгжлийг тодорхой үзэл баримтлал түүнд суурилсан бодлогоор нарийвчлан тооцож, баримжаалан чиглүүлж байдаг. Хөгжлийн энэхүү цогц баримтлал, бодлого нь бүхэлд нь улс төрийн хүрээнээс гарч ирдэг. Иймд хөгжлийг залж чиглүүлэхэд чиглэсэн бодлого-зохицуулалтыг ерөнхийд нь улс төрийн үзэл баримтлал, бодлого хэмээн оноон томъёолдог. Тиймээс ч хөгжлийн бодлого бол эдийн засаг дахь улс төрийн нөлөөллийн нэгэн илэрхийлэл болдог. Тэгвэл бидэнд хөгжлийн энэхүү оновчтой бодлого гээч зүйл байна уу? хэрвээ энэ нь ямар нэг хэмжээгээр байдаг бол түүний хэрэгжилтийн байдал төлөв ямар байна вэ? гэх зэрэг асуудал сонирхол татах нь зүйн хэрэг.

^{*} Fish, M. Steven. Mongolia: Democracy Without Prerequisites. Journal of Democracy – Volume 9, Number 3, July 1998, pp. 127-141

Өнөөдөр Монголын эдийн засгийн хөгжлийн бодлого зүүнээс баруун тийш чиглэсэн тогтворгүй шинжтэй байна. Тус оронд нэг хэсэгтээ зүүний социал-демократ чиглэл харьцангуй давамгайлах өнгө аястай байснаа өнөөдөр хэлбэрэлтгүй неолиберал, либертари чиглэмжтэй болсон. Ер нь Монгол орон ардчилалд анх хөл тавихдаа ардчиллын хөгжлийн “Дорнын загвар” гэж хэлж болох “Азийн баруудын загвар”-ыг сонгож түүгээр замнаагүй юм. Харин үүний оронд Өрнийн ардчиллын сонгодог “либерал хөгжлийн загвар”-ыг тууштай сонгон хэрэгжүүлсэн байдаг. Одоо бодоход бид хөгжлийн энэхүү бодлого, загварыг өөрийн орны өвөрмөц онцлогт дээд зэргээр нийцүүлэн түүнд бүтээлчээр хандах учиртай байж. Харамсалтай нь бид ингэж чадаагүй. Үгүй ядаад бид орчин үеийн хөгжлийн сонгодог либерал үзэлд ихээхэн хувьсал өөрчлөлт гарах болсоныг ч анзаарах сөхөөгүй түүнийг муйхараар хэрэгжүүлсэн нь том алдаа байсан нь одоо ойлгогдож байна. Тэр ч байтугай ер нь Дорнын тэр дундаа нүүдлийн соёл иргэншлийн давтагдашгүй онцлог уламжлалтай улс орны хувьд Өрнийн ардчиллын сонгодог “либерал загвар” хэр нийцэмжтэй байсан вэ? гэсэн асуудлыг ч сөхөн тавьж, нарийвчлан авч үзэх шаардлага байх шиг байна.

1980-аад оноос, тодруулбал “Хүйтэн дайн” дуусгавар болсон 1990-ээд оны эхэн үеэс Тетчеризм, Рейгенизм, неолиберализм, “Вашингтоны зөвшилцөл” зэрэг үгсээр олонд танигдсан зах зээлийн либералчлалын онол дэлхийн улс төрийн бодлогод ноёрхох болсон юм. Энэ онол нь улс орнуудын нийгэм, дэлхийн эдийн засгийн аль алин нь өөрөө өөрийгөө зохицуулах зах зээлийн хуулиар зохицуулагдах ёстой гэдгийг хүчтэй дэмжээд зогсохгүй “бүтцийн өөрчлөлт” хэмээх бодлогын удирдамж боловсруулагдсан байна. Олон улсын валютын сан, Дэлхийн банк зэрэг олон улсын байгууллагууд бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг хөгжиж буй олон оронд хэрэгжүүлсэн.⁹ Гэвч амьдрал дээр алив улс орон өөрийн онцлогт тохирсон хөгжлийн өөрийн гэсэн өвөрмөц бодлого, баримтлалтай байх ёстой бөгөөд тэгэхдээ энэ нь дэлхийн улс орнуудын хөгжлийн ерөнхий хандлага, нийтлэг жам ёсноос гажсан биш, харин үндсэн агуулгаараа тэдгээрийн онцлог тусгал хэлбэрээр хэрэгжих учиртай юм гэдэг нь одоо сайтар ойлгогдож байна.

Монгол орны хөгжлийн философи ямар ч суурь үндэстэй байгаа гэсэн өөрийн онцлогт нийцэн тохирсон нийгмийн хөгжлийн цогц баримтлал, бодлого зайлшгүй хэрэгтэй. Ийм баримтлал бодлогыг төрөөс гардан боловсруулдаг бөгөөд тэдгээрийг засаглалын харилцаанд орсон улс төрийн намууд өөр өөрсдийн улс төрийн үзэл баримтлал, хөтөлбөр, бодлогын онцлогтой уялдуулан бүтээлчээр хэрэгжүүлдэг жамтай. Гэвч нийгмийн хөгжлийн үйл явцыг бодлогоор залж чиглүүлэх энэхүү нийтлэг жишиг манайд ихээхэн алдагдсан нь тодорхой байна.

Тодорхой улс орнуудад хөгжлийн урт хугацааны стратегийн бодлого, төлөвлөгөө хэрэгжиж байх ёстой. Түүнээс биш тухайн сонгуулиар ялж гарч ирсэн олонхи болсон намын хөтөлбөр, бодлого дангаараа давамгайлах учиргүй. Амьдрал дээр төрийн бодлогод суурилсан аль нэг намын бодлого хэрэгжиж байх ёстой. Гэтэл бодит байдал дээр тиймгүй байна. Өнөөдөр Монгол орны хөгжлийн урт хугацааны стратегийн бодлого төлөвлөгөө бус, харин засгийн эрхэнд байгаа аль нэг намын бодлого улс орныг залж байна. Үүний улмаас хөгжлийн тодорхой философи, үзэл баримтлалд суурилсан хөгжлийн тогтвортой урт хугацааны стратегийн бодлого үгүйлэгдэх боллоо. Уг нь бидэнд хөгжлийн энэхүү цогц бодлого байхгүй биш байгаа юм. Түүнийг 2008 онд Монголын парламент боловсруулан баталсан байдаг. Түүнчлэн 2012 онд Монгол Улс мэдлэг суурилсан эдийн засагтай орон болно гэсэн агуулга бүхий тунхаг бичгийг ч баталсан. Харамсалтай нь энэ бүхэн нь ажил болж хэрэгжиж чадаагүй.

Өнөөдөр манайд аль ч улс төрийн хүчин гарлаа гэсэн ерөнхий агуулгаараа зайлшгүй хэрэгжиж байдаг хөгжлийн тогтвортой, урт хугацааны стратегийн цогц бодлогыг дахин сайтар нягтлан, ард олон түмний санаа бодлыг тусган боловсруулан батлаж, түүнийг хэлбэрэлтгүй хэрэгжүүлэх хэрэгтэй байна. Энэ нь нийгмийн амьдралын тодорхой тусгай салбар, чиглэлийг түлхүү баримжаалсан биш, харин улс орны хөгжлийн бүх талыг цогц хамарсан иж бүрэн шинжтэй хөгжлийн нэгдмэл бодлого байх ёстой юм. Түүний гол агуулга нь Харвардын Их сургуулийн профессор Даниел Беллийн томъёолсон “аж үйлдэржилтийн дараах нийгэм” буюу мэдээлэл, мэдлэгт тулгуурласан оюунжсан хөгжлийн загварт суурилах учиртай болов уу. Энэ нь мэдээлэлжсэн нийгмийн мэдлэгт суурилсан эдийн засгийн хөгжлийн хөгжлийн үзэл баримтлал юм. Үүнийг АНУ-ын судлаач Жон Найсбит “Аж үйлдвэрийн нийгэмд стратегийн нөөц нь капитал юм. Харин мэдээллийн нийгэмд бид мэдээллийн үйлдвэрлэлийг системчилж, уураг тархины хүч чадал, түүний ашиглалтыг өсгөж байна... Эрх мэдлийн шинэ эх сурвалж

⁹ Социализмын дараах Монголчууд: улс төр, эдийн засаг, шашин. УБ., 2012, 76 дахь тал

нь цөөнхийн гарт байдаг мөнгө биш, олонхийн гарт байдаг мэдээлэл болж хувирна"¹⁰ хэмээн томъёолсон байдаг. Өнөөдөр дэлхийн эдийн засгийн бодлогын нийтлэг хандлагыг даяаршил, технологийн дэвшил, мэдлэгийн эдийн засаг, олон соёлын огтолцоолоор тодорхойлогдож байна. Чухамхүү хөгжлийн энэ нийтлэг баримтлал, хандлага манай өнөөдрийн хөгжлийн цогц бодлогын суурь үндэс байх учиртай юм. Хэрвээ бид мэдлэгт суурилсан хөгжлийн бодлогыг хэрэгжүүлж чадвал түүний хэтийн үр дүн нь хүний хөгжил, экологийн тэнцвэр, эдийн засгийн өсөлт, ядуурлын бууралт, өндөр технологийн нэвчилт, үндэсний аюулгүй байдал, тогтвортой сайн засаглал байх болно.

Эрх зүйн орчны нөлөөлөл. Эдийн засгийн хөгжлийн бодлогыг хууль, эрх зүйн баталгаатай болгож байж гэмээн энэ нь сая амьдралд хэрэгжих боломжтой болдог. Энэ агуулгаараа эрх зүйн орчны нөлөө нь эдийн засаг дахь улс төрийн нөлөөллийн нэг хэлбэр болдог. Монголд орон ардчилалын замаар замнаж эхэлсэн 90-ээд оны эхэн үеэс зах зээлийн эдийн засгийн жам ёсны дагуу түүнд нийцсэн хууль эрх зүйн шинэ орчныг бүрдүүлэх чиглэлээр ихээхэн хүч чармайлт тавих болсон. Энэ үед социалист төлөвлөгөөт эдийн засгийн хөгжилд тохирсон хуучин хууль тогтоомжуудыг бүхэлд нь шинэ Үндсэн хууль болон нийгмийн амьдралын шинэ орчинтой нийцүүлэн өөрчлөх; ардчилал, зах зээлийн эдийн засгийн шинэ орчинд тохирсон тулгуур хууль, тогтоомжуудыг боловсруулан батлах; хууль хэрэгжүүлэх түүний биелэлтийг хангах механизмыг шинээр үүсгэн төлөвшүүлэх; хууль тогтоомжийг олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчимд нийцүүлэх; хууль зүйн судалгаа болон эрх зүйн боловсрол, хүн ардын эрх зүйн шинэ соёл, ухамсарыг төлөвшүүлэх; мэдээллийн шинэ технологид суурилсан эрх зүйн мэдээлэл, сурталчилгааны үр ашигтай, шуурхай, оновчтой механизм, арга барилыг бүрдүүлж, хэрэгжүүлэх; хүний эрхийг баталгаатай хангах эрх зүйн найдвартай орчин нөхцөлийг бүрдүүлэх зэрэг амаргүй төвөгтэй зорилтыг хэрэгжүүлэх хэрэгтэй болсон билээ. Энэхүү зорилтуудыг шийдвэрлэхгүйгээр нийгэм, ардчиллын үр ашигтай хөгжлийн тухай санахын ч хэрэггүй байлаа.

Энэ бүхэнтэй уялдан Монгол Улсын шинэ Үндсэн хуульд нийцүүлэн нийгмийн харилцааг зохицуулж байсан хуучин хуулиудыг өөрчлөх, эрх зүйн цогц шинэтгэлийн хүрээнд 1998 онд Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, 2001 онд Монгол Улсын хууль тогтоомжийг 2004 хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл, 2003 оноос хүний эрхийг хангах Үндэсний хөтөлбөрийг батлан гаргаж эрх зүйн шинэтгэлийг хэрэгжүүлэх явцад чиг баримжаа болгож байлаа.

Эрх зүйн шинэтгэлийн үйл явц өнөөдөр ч үргэлжилж байгаа гэж хэлж болно. Гэвч өнөө үед хууль тогтоомжуудын давхардал, тэдгээрийн эрх зүйн зохицуулах чадамж, хүч боломж сулрах, зарим талаар эдийн засгийн хөгжилдөө чөдөр тушаа болох; улс орны нийтлэг эрх ашиг гэхээсээ илүү улс төрчид, улс төрийн тодорхой бүлэг, улс төрийн хүчний сонирхол, эрх ашигт хөтлөгдөх болон лобби бүлгийн шахалтын дор явцуу хууль тогтоомжууд гаргах гэж оролдох; хууль дээдлэх, хуулийн зохицуулалтын дор амьдрах дадал зуршил, соёл бүх түвшиндөө сулрах, хуулийн зохицуулалт дагасан хяналт-хариуцлагын механизм илтэд үгүйлэгдэх гэх зэрэг зохисгүй үзэгдэл оршин илэрсээр байгааг цаг алдахгүй анхааралдаа авч, засч залруулах нь нийгмийн эдийн засаг, ардчиллын хөгжлийн чухал нөхцөл болох учиртай юм. Тиймээс ч өнөөгийн УИХ-ын зүгээс энэ чиглэлээр бага биш зүйл хэрэгжүүлж буй төдийгүй шинэчлэлийн Засгийн газрын зүгээс ч хууль тогтоох засаглалын нэгэнт гаргасан хууль тогтоомжийг мөрдөн хэрэгжүүлэх тал дээр нилээдгүй анхаарал тавин ажиллаж буйг ор үгүйсгэх аргагүй юм. Энэ бүхэн нь Монгол орны эдийн засгийн хөгжлийн улс төрийн чухал хүчин зүйл болж буйг тэмдэглэе.

Улс төрийн тогтвортой байдал ба нөлөөлөл. Нийгмийн эдийн засгийн хөгжилд үзүүлэх улс төрийн хүчин зүйлийн нөлөөллийн бас нэг хэлбэр нь улс төрийн тогтвортой байдал болдог. Улс төрийн тогтвортой байдал нь үнэндээ нийгэм хэвийн оршин тогтнохын үндсийн үндэс болдог. Тогтвортой байдал нь бүх амьд организм, нийгмийн бүхий л үзэгдэл, үйл явцад хамаатай өргөн нийлмэл ойлголт. Түүний нэг хэлбэр нь улс төрийн тогтвортой байдал юм. “Улс төрийн тогтвортой байдал” хэмээх нь улс төрд оролцогч субъект, улс төрийн институтын хоорондын тэнцвэр, зохицол, ойлголцол, ухаалаг зөвшилцл, үйл байдлын чадамжит харилцаанд суурилсан улс төрийн гайван хэвийн бодит төлөв байдал юм.

Хэрвээ улс төрийн ийм тогтвортой байдал үгүйгээр хөгжлийн ямар ч сайн бодлого-эрх зүйн зохицуулалтыг хэрэгжүүлэх аргагүй. Оксфордын Их сургуулийн профессор Пол Коллер *"Адагт үлдсэн*

¹⁰ Мянганы хөгжлийн зорилтуудад суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого боловсруулах асуудалд. Онол, практикийн бага хурлын материал. Уб.2006. 17 дахь тал

тэр бум: хамгийн ядуу орнууд хэрхэн сүйрэн унаж байгаа тухай” хэмээх номыг 2007 онд бичсэн байдаг. Тэрээр энэхүү номондоо ядуу улс орнуудын сүйрэлийн “нууц” нь өөрсөнд нь байна гэдгийг олон талын судалгаанд суурилан дүгнэсэн байдаг. Түүний бичсэнээр ядуу орнууд гаднаас ихээхэн хэмжээний зээл тусламж авдаг, бас ч үгүй хөгжлийн тодорхой бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх гэж оролддог. Харамсалтай нь тэдгээр орнуудад ёс юм шиг жагсаал, цуглаан, бослого, тэмцэл тасардаггүй. Энэхүү бослого тэмцлийн гол уриа нь нийтийн сайн сайхны төлөө, байгаль орчныг хамгаалах, орлогыг тэгш хуваарилах, үндэстнээ хайрлах, гадаадын хөрөнгө оруулагч шулаачдыг эсэргүүцсэн сонсоход чимэгтэй, үнэнхээр л анхаарах учиртай аль дөмөг, олигтой гэсэн “иргэнлэг” лоозунг байдаг. Гэвч тэмцлийн цаад зорилго санаа нь үнэндээ нийтийн сайн сайхны төлөө, байгаль орчныг хайрлан хамгаалах, өөрсдийн баялагийг өөрсддөө гэсэн уриатай нь огтхон ч авцалдадгүй, харин үүний цаана ердөө л хэсэг бүлгийн ашиг сонирхол, эрх мэдэл, мөнгө, эдийн засгийн шунал байдаг нь хачирхалтай.

Хуулийн тогтворгүй байдал, улс төрийн найдваргүй хандлага, авилгын сүлжээ нь гадаадын хөрөнгө оруулагчдыг байтугай, дотоодын компаниудыг хүртэл айлган зугтаах явдал руу шахдаг аж. Нэгэнт найдваргүй зах зээл дээр үйлээ үзэж байгаа дотоодын компаниуд хөрөнгөө гадагш нүүлгэж эхэлдэг аж. Африкийн хамгийн ядуу 30 орны нийт хуримтлалын 70 хувь нь хөгжингүй орнуудад гарчихсаныг тооцолсон байна. Үүний дараа эдгээр үгээгүй найдваргүй орнуудад “тархины дүрвэлт” гээч үзэгдэл болдог гэнэ.¹¹ Ингэж ухаалаг бус популизмд суурилсан улс төрийн тогтворгүй байдал нь ямар ч хүч чармайлт, эдийн ямар ч сайн хөтөлбөрийг нэг мөсөн утга учиргүй болгож, үйл явцын эерэг бүхнийг орвонгоор нь эргүүлж орхидог байна. Үүний үр дүнд өнөөх л урьдын ядуу тарчиг байдал, ангалын ёроол дахь зовлон зүдгүүр, бэрхшээл асуудалтайгаа хамт үлддэг байна.

Ингэхлээр улс төрийн тогтвортой байдал нь аль ч улс оронд тэр дундаа ардчиллын замаар замнаж буй манайх шиг орнуудад үнэхээр “*ус, агаар*” адил хэрэгтэй болох нь харагдаж байна. Иймд манай улс төрчид, засаглалын харилцаанд байгаа улс төрийн нам хүчнүүд эв эеэ ямагт хичээж, хамтын ойлголцол, зөвшөлцөл, харилцан бодлогын дэмжлэгт суурилсан улс төрийн тогтвортой байдлыг бий болгохыг хичээх нь нэн чухал байна.

Хяналт-хариуцлагын тогтолцоо ба нөлөөлөл. Хяналт-хариуцлага бол ардчиллын оршин тогтнох нэгэн амин сүнс, үндсэн нөхцөл, хүчин зүйл болдог. Хуулийн хэрэгжилтийг дагасан тодорхой хяналт-хариуцлагын механизм үйлчлэхгүйгээр нийгмийн эдийн засгийн үр нөлөөтэй хөгжлийн тухай ярих аргагүй. Манай улс төр шинжээчдийн үзэж байгаагаар Монголд ардчилсан институтууд бүтэц, бүрдэл, хэлбэрийн талаасаа муугүй төлөвшиж, ардчилсан нийгэмд байдаг тэр дүр төрх нүдэнд ил харагдаж байгаа. Харин институциональ бүтцийн үйлчлэн орших үйл ажиллагааны функциональ харилцаа буюу босоо ба хэвтээ чиглэлийн механизмууд, ажил хэргийн болон эрх, үүрэг, хариуцлагын сүлжээнүүд өнөөдөр маш сул ажиллаж байгаа гэж үзэж болно. Түүний эрх зүйн орчин ч хангалтгүй байна.¹² Ийм нөхцөлд өнөөгийн ардчилсан “сайн засаглал”-ын чухал элемент болсон хяналт-хариуцлагын механизмыг бүхэл тогтолцооны түвшинд бүрдүүлэн төлөвшүүлэх шаардлага зүй ёсоор гарч ирж байгаа юм.

Нийгэмд хууль-хуулийн хэрэгжилт-хяналт-хариуцлага хэмээх хоорондоо харилцан хамаарал бүхий цогц хүчин зүйлийн механизм бодитой үйлчилж байж нийгмийн алив өөрчлөлт, хөгжил, түүний үр ашиг, нөлөөллийн тухай асуудал гарч ирдэг. Хэрвээ ардчиллын энэ чухал бүрдэл механизм ажиллахгүй бол нийгмийн хөгжлийн ямар ч сайн бодлого, эрх зүйн зохицуулалт байлаа гээд энэ нь үр ашгаа өгдөггүй болох нь амьдралаас харагдаж байна. Өнөөдөр манайд илтэд үгүйлэгдэж байгаа зүйл бол бодитой, үр нөлөөтэй хяналт-хариуцлагын механизм түүний хэрэгжилт юм.

Хяналт, хариуцлага нь нэгэн зүйлийн салшгүй хоёр тал юм. Хяналтгүйгээр ямар нэг хариуцлага, хариуцлаггүйгээр бодитой үнэн хяналт гэж үгүй гэдэг нь жам ёсны зүйл. Хяналт бол болж буй үйл явцын дотоодод өрнөж буй тодорхой үйл ажиллагаа, арга хэмжээний явц байдалд үнэлэлт дүгнэлт өгөх, үйл явцыг зөв чиглэл гольдролд нь оруулахад чиглэсэн хөндлөнгийн үр ашигтай нөлөөлөл юм. Бодитой хяналтаас тодорхой хариуцлага гарч ирдэг. Хариуцлага бол хоёр талт агуулгатай зүйл. Хариуцлага нь нэг талаас аль нэг ажил хэргийг хариуцан хэрэгжүүлэх үүрэг, даалгавар, нөгөө талаас ажил хэргийн үр дүнгээс хамааран гарч ирсэн шийтгэл, зэмлэл, бас шагнал юм. Философич Б.Даш-Ёндон багшийн үзэж байгаагаар “нийгмийн хариуцлага гэдэг бол нийгэм одоогийн үйлдлийнхээ цаашдын үр дагаварыг

¹¹ Б.Баабар. Адагт очих жор. “Өдрийн сонин. 2014, № 026

¹² Монгол Улсын ардчилсан хөгжил ба Үндсэн хууль. Эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл. УБ, 2005, 11 дахь тал

урьдаас бодож, ирээдүйд бэлтгэх лүгээ уялдсан ёс зүйн ойлголт юм. <...> Хариуцлага гэдэг маань одоо ч, ирээдүйд ч хохирол гаргахгүй байх шаардлага мөн.”¹³ Гэвч ёс зүйн ойлголт болсон хариуцлага нь нийгмийн харилцааны хүрээнд олон дүрс, хэлбэрээр дамжин илэрдэг. Энэ хүрээнд ёс зүйн, сонголт хийх, шийдвэр гаргах, улс төрийн, бүлгийн, иргэний, хувийн тэр ч байтугай компанийн гэх зэрэг хариуцлагын олон дүрс хэлбэрийг ялган үзэж болдог.

Орчин үед хяналт-хариуцлагыг ардчилсан “сайн засаглал”-ын салшгүй бүрдэл түүнийн нэг үндсэн атрибут хэмээн үздэг. Хариуцлагын тогтолцоо төрийн албанд шударга ёсыг дэмжихэд туслана. Хариуцлагын тогтолцоо бол сайн засаглалын тулгуур багана бөгөөд энэ нь төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагууд үйл ажиллагааныхаа үр дүнг анхаардаг, тодорхой зорилго тавьж, түүнд хүрэх үр нөлөө бүхий стратегийг боловсруулдаг, гүйцэтгэлдээ хяналт-шинжилгээ хийж, тайлагнадаг байхыг хэлнэ. Энэ нь хувь хүн, байгууллага ажлын бодитой хэмжигдэх үр дүнгийн төлөө хариуцлага хүлээнэ гэсэн үг юм. Өнөө үед сайн засаглалын хүрээнд хариуцлагын санхүүгийн, улс төрийн, захиргааны хэлбэрийн илүүтэй онцолдог.

Монголд өмнө тэмдэглэсэнчлэн хяналт-хариуцлагын механизм үнэхээр илтэд суларсан гэж хэлж болно. Энэ нь нэн ялангуяа төрийн байгууллагын бүх түвшинд тэр дундаа төрийн дээд, дунд түвшинд нэн тодорхой илэрч байна гэхэд хэлсдүүлэл болохгүй юм. Хяналт-хариуцлага сулаас болж төрийн өмчийг эзэнгүйдүүлэх, хуйвалдах, идэж шамшигдуулах, авилгалд идэгдэх, хуулийг гууль болгох, ёс зүйн алдаа дутагдал гаргах, хариуцлагаас ёс бусаар мултрах зэрэг зохисгүй үзэгдэл газар авах үндсэн нөхцөл болж байна. Энэ бүхэн нь улс орны эдийн засгийн хөгжлийг боймлож буй нэгэн ноцтой хүчин зүйл болж байна. Хариуцлага нь улс төрд оролцож буй бүх субъект, улс төрчид, улс төрийн институт, иргэдийн аль алинд нь хамаатай нийтлэг зарчим шаардлага юм. Тийм ч учраас амьдралаас үүдсэн хяналт-хариуцлагын энэхүү шаардлагыг хүн бүр ёс зүй, ухамсар, соёл, үйл байдал, ажил хэргийн бүхий л хүрээ, түвшинд ёсчлон хэрэгжүүлэх хэрэгтэй байна. Түүнчлэн үүнтэй уялдсан хууль эрх зүйн механизмыг ч тов тодорхой болгон шинэчлэн боловсронгуй болгох шаардлага ч гарч ирэх нь зүйн хэрэг. Тодорхой хэлбэл өнөөдөр хяналт-хариуцлагыг бодитой хэрэгжүүлэх гол арга зам нь ухамсар, ёс зүй, төрийн бодлого, эрх зүй зохицуулалт, мэдээлэл, сургалт, сурталчилгааны бүхий л механизмыг амьд бөгөөд бодитой, ил тод, үр нөлөөтэй хэрэгжүүлэх явдал юм. Хяналт-хариуцлагатай холбоотой энэ бүх тулгамсан асуудлыг цаг алдалгүй анхааран шийдвэрлэх нь улс орны нийгмийн эдийн засгийн хөгжилд үзүүлэх улс төрийн нөлөө хүчин зүйлийн эерэг нөлөөллийг нэмэгдүүлэх нэг чухал шижим үндэс болох учиртай юм.

НОМ ЗҮЙ

Монгол хэл дээр

1. Б.Даш-Ёндон. Цаг үе:сэтгэл бодрол, философи. Уб.,2012
2. Б.Даш-Ёндон. “Монголын хөгжлийн философи: асуудал, аргачлал, ашиг тус” Уб.,2013
3. М.Батчимэг. Эдийн засгийн өрнөл ба улс төрийн замнал. “Социализмын дараах Монголчууд: улс төр, эдийн засаг, шашин” Уб.,2012
4. Социализмын дараах Монголчууд: улс төр, эдийн засаг, шашин. Уб.,2012
5. Мянганы хөгжлийн зорилтуудад суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого боловсруулах асуудалд. Онол, практикийн бага хурлын материал. Уб.,2006
6. Б.Баабар. Адагт очих жор. “Өдрийн сонин. 2014, № 026
7. Монгол Улсын ардчилсан хөгжил ба Үндсэн хууль. Эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл. Уб.,2005, 11 дахь тал

Англи хэл дээр

1. Polanyi, K. 2001. The Great Transformation: The Political and Economic Origins of Our Time. Boston: Beacon Press
2. Block, P. 2001. “ Introduction” in Polanyi, K. The Great Transformation: The Political and Economic Origins of Our Time. Boston: Beacon Press.
3. Lipset, Seymour. Some social requisites of democracy: Economic development and Political legitimacy. American political science review. 1959, A comparative analysis of the social requisites. 1993.
4. Determinants of Economic Growth. 1997, Determinants of democracy. 1999
5. Fish, M. Steven. Mongolia: Democracy Without Prerequisites. Journal of Democracy – Volume 9, Number 3, July 1998

¹³ Б. Даш-Ёндон. Цаг үе:сэтгэл бодрол, философи. Уб.,2012, 94-95 дахь тал